

УЛААНСАН ХК

2026. 4. 29

№ /

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн оноосон нэр өөрчлөх, дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улаансан ХК-ийн оноосон нэрийг Ард майнинг групп болгон **ӨӨРЧИЛСҮГЭЙ.**
2. Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт дараах өөрчлөлтийг оруулж, дүрмийг **БАТАЛСУГАЙ.** Үүнд:
а/ Бүтэн нэр "Ард Майнинг Групп" ХК,
б/ Англиар: "Ard Mining Group" Joint Stock Company
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий бүртгэлийн байгууллагад холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батбаярт **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА



П.БАТБАЯР

УЛААНСАН ХК

2026. 4.29

№ 2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлоолон Удирдах Зөвлөлийн 2026 оны
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улаансан ХК-ийн Төлоолон Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар **БАТАЛСУГАЙ.**
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тус тус **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА



П.БАТБАЯР

Улаансан ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын 2 дугаар тогтоолын Хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ТӨСӨВ

	Улирал	Жил
ТУЗ-ийн дарга	1,500,000	6,000,000
Хорооны дарга	1,000,000	4,000,000
Хорооны дарга	1,000,000	4,000,000
Хорооны дарга	1,000,000	4,000,000
ТУЗ гишүүн	750,000	3,000,000
ТУЗ гишүүн	750,000	3,000,000
ТУЗ гишүүн	750,000	3,000,000
ТУЗ гишүүн	750,000	3,000,000
ТУЗ гишүүн	750,000	3,000,000
Нийт	8,250,000	33,000,000

УЛААНСАН ХК

2026. 4.29

№ 3

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улаансан ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг **БАТАЛСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА



П.БАТБАЯР